



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар A/202

Улаанбаатар хот

Иргэдэд газар эзэмших эрх
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/77 дугаар захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны A/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинээр газар эзэмших хүсэлт ирүүлсэн 11 (Арван нэг) иргэнд гэр бүлийн хэрэгцээнд зориулан, газар эзэмших эрхийг олгож, хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмших эрх олгогдсон иргэдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг хавсралтад нэр заагдсан иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД